

НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР

2020.09.04-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ШУУРХАЙ ХУРЛААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

2020.09.17

№	Товч агуулга	Биелэлт
1	Үр хөндөлтийн мэдээллийг 2020 оны 09 сарын 11-ны өдрийн дотор ирүүлэх	Үр хөндөлтийн нийт мэдээллийг 2020 оны 09 сарын 10, 11-ны өдрүүдэд 2 хувааж Нийслэлийн эрүүл мэндийн газрын статистикийн мэргэжилтэн Оюунгэрэлийн <a href="mailto:oyuka.adiya@gmail.com">oyuka.adiya@gmail.com</a> цахим шуудангийн хаяг руу судалгааг хугацаанд гаргаж илгээсэн .
2	Үзлэгийн цаг захиалгын үйлчилгээг зохицуулах НЭМГ-ын даргын 02 албан даалгаврын хэрэгжилтийг хангах, ажлын тайланг ирүүлэх	Тус амаржих газрын Амбулаториор үйлчлүүлэгсдийг цахим бүртгэлд бүртгэж товлосон цагт үзлэг, оношлогоог хийж 30376 эх, эмэгтэйчүүдэд эх барих болон сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлсэн.
3	Коронавируст ковид 19 халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээний үйл ажиллагаа эрчимжүүлэх	<p>COVID-19 халдварын дэгдэлтийн үед /шаардлагатай тохиолдолд/ Нийслэлийн Өргөө амаржих газрын өргөтгөлийн барилгын эмэгтэйчүүдийн тасгийн 1 болон 3 давхарыг чөлөөлж нийт 30 ор гарган ажиллана.</p> <p><b>Нэг давхарт:</b> Эмчлүүлэгчийг эрэмбэлэн ялгах, хүлээн авах үзлэг оношлогоо болон шинжилгээ сорьц авах хэсгийг</p> <p><b>Гурван давхарт:</b> 30 ор бүхий төрөх өрөө, хагалгааны өрөө, нярайн эрчимт эмчилгээний өрөө, сэхээн амьдруулахын өрөө зэргийг иж бүрэн тоноглон ажиллуулахаар бэлдсэн. 30 ор дэлгэн ажиллах үеийн төлөвлөгөө боловсруулан гарын авлага хэлбэрээр гаргасан. Уг гарын авлагад шаардлагатай нөөцийн бэлэн байдал болон багуудын хийх ажлыг тодорхойлон оруулж өгсөн.</p> <p>НӨАГ-ын эмийн сан нь дэлхийн нийтийг хамарсан цар тахлын үед бэлэн байдлыг хангаж ажиллах үүднээс шинээр эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн өрөө гаргаж тохижуулан 30-50 хүний нөөцтэйгөөр эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Тухайн нөөцийг өдөр тутмын эмчилгээ үйлчилгээнд ашиглахгүйгээр байнгын бэлэн байдалд хадгалж эмийн хугацаа, савлалт, хадгалалтын горимыг өдөр бүр шалган тэмдэглэж байна.</p>
4	Эхийн эндэгдлийг бууруулах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах, жирэмсний хяналтын нэг цэгийн үйлчилгээг сайжруулах	<p>НӨАГ нь эхийн эндэгдлийн бууруулах чиглэд дараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2020 онд ноцтой хүндрэлийн 20 тохиолдлыг 9 эмнэлзүй эмгэг судлалын хурлаар хэлэлцүүлсэн.</li> <li>• Жижүүр эмч нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 10 үндсэн үзүүлэлтээр гаргаж сар бүр удирдлага болон эмч нарт мэдээлэл өгч ажилласан. /Сар бүр/</li> </ul>

- Мэс заслын үеийн халдвар хамгаалалын дэглэмийн хяналт, үнэлгээг 3 албадын 7 гишүүд 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулан 21 мэс засалд үнэлгээг хийсэн.
- ЭМТҮЧАБ-ын албаны Эмнэлгийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай” тушаалаар орон тооны бус 11 гишүүн, Чанарын багийн 25 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсан. Чанарын дотоод хяналтыг 5 хянах чиглэлээр 29 хяналтын чек листээр хяналт хийсэн байна. Нийтдээ 116 хяналтын хуудастай үүнээс 70 хяналтын хуудас шинээр боловсруулан гаргасан байна.
- 34 төрлийн ижил мэргэжилтний үнэлгээний хяналтыг, 10 удаа, 30 хяналтын хуудсаар хийсэн байна. 2020 онд шинээр 70 ш хяналтын хуудас боловсруулан тасаг нэгжид хяналт хийсэн.
- Дүргүүдийн эх барих эмэгтэйчүүдийн мэргэжилтэнтэй тухай бүрт утсаар холбогдож 39 үл тохирлыг мэдээлсэн
- Улирал бүр дүүрүүдтэй холбоотой үл тохирлыг нэгтгэн цахим шуудангаар эх барих эмэгтэйчүүдийн мэргэжилтэнд илгээдэг
- Перинаталь эндэгдэлийн эмнэлзүйн эмгэг судлалын хурал хийж 2 тохиодол хэлэлцүүлсэн. 16 тохиолдол дээр 23 эмчийн чанарын талонг цоолсон
- 2020 оны 04-р сарын 10-ны өдрийн НӨАГ-ын даргын А/31 тушаалаар “Ижил мэргэжилтний үнэлгээ хийх” журмыг шинэчлэн батлуулсан. Уг журмаар 116 ижил мэргэжилтний үнэлгээний хуудсыг батлуулсан болно.
- Анхан шатны бичиг баримтны хөтлөлтийн үнэлгээнд өвчний түүх- 2746, төрөлтийн түүх- 1928, нярайн түүх- 1810, мэдээгүйжүүлгийн хуудас-910, үр хөндөлтийн түүх-410, сувилгааны түүх, мэс заслын үеийн хяналтын хуудас, эмчилгээний хуудас зэрэг нийт 25 хяналтын хуудас нийт 6674 АШББ-д үнэлгээ хийгдэж. /20.01.24-02.02/ Анхан шатны бичиг баримтны хөтлөлт дээр давхардсан тоогоор 204 удаа эмч нарт сануулга өгсөн

Нийт эмч, эмнэлгийн ажилтнуудыг хамруулан 14 хоногийн турш байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх дотоод журам, тушаалуудыг нээлттэй уншуулж танилцуулсны дагуу 2020.05.28,29-ны өдрүүдэд “ДУРААРАА БИШ ЖУРМААРАА АЖИЛЛАЦГААЯ” ЧАНАРЫН ӨДӨРЛӨГ-ийг танхимаар болон ZOOM аппликейшн хослуулан ашиглаж нийт 481 ажилтнууд, 33 резидент эмчийн хамруулан амжилттай, үр дүнтэй зохион байгуулсан байна.

5	Өвөлжилтийн бэлэн байдлыг хангах	<p>2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг байгууллагын даргаар батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэн хугацаандаа буюу 09 дүгээр сарын 15-ны өдрөөс дулаан хангамжаа бүрэн авч ажиллаж байна.</p> <p>2020 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр манай өргөтгөлийн байрны гадна хананаас 02 метрийн зайнд 125мм-ийн голчтой дулааны шугам цоорч гэмтсэнийг манай сантехникийн ажилтнууд хугацаа алдалгүй зассаг хэвийн горимд оруулсан. Энэхүү гэмтэл нь анх уг дулааны шугамыг суурилуулахдаа технологи, стандарт, зөрчсөнтэй холбоотой байсан тул бид Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт хандаж, байцаагч ирж газар дээр нь шалгаж явсан ба одоо гарах дүгнэлтийг хүлээж байна. /Гарах дүгнэлтийг албан тоотоор хүргүүлэх болно/</p>
6	<p>Коронавируст халдвараас гадна улирлын томуугийн өвчлөл, тарваган тахал, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх мэдээлэл, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ХЭМБ-ын хэвлэлийн ажилчдыг хамруулсан сургалтанд ажилчдаа идэвхитэй оролцуулах</p>	<p>НЭМГ-аас гаргаж мэдээлэлж буй зөвлөгөө, мэдээ, постеруудыг Нийслэлийн Өргөө амаржих газар facebook, Уугантөрөх page-ээр дамжуулан шэйр хийхээс гадна <a href="http://www.urguu-amarjikh.ub.gov.mn">www.urguu-amarjikh.ub.gov.mn</a> цахим хуудсанд мэдээллийн эх сурвалжийг дурдаж мэдээг байршуулдаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Улирал, цаг уурын байдлаас шалтгаалсан зонхилон тохиолдох өвчлөл НЭМГ-аас гаргасан постерууд, видео зөвлөмж</li> <li>• НЭМГ-ын харъяа эрүүл мэндийн байгууллагуудын цаг үеийн мэдээ, мэдээлэл</li> <li>• НЭМГ-ын даргын үүрэг даалгавар, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгийн мэдээ, мэдээлэл</li> </ul> <p>Коронавируст халдвараас гадна улирлын томуугийн өвчлөл, тарваган тахал, угаарын хийн хордлогоос урьчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, зөвлөгөө олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шинэ Коронавирусийн /Ковид 19/ халдвараас урьчилан сэргийлцгээе /постер 8 удаа/</li> <li>• Тарваган тахлын илрэх шинж тэмдэг /цуврал зөвлөмж 6 удаа/</li> <li>• Тарваган тахлаас сэргийлцгээе /постер 4 удаа/</li> <li>• Угаарын хий гэж юу вэ? /зөвлөмж 2 удаа/</li> <li>• Угаарын хийн хордлогын үед хэрхэн анхны тусламж үзүүлэх вэ? /цуврал зөвлөмж 4 удаа/</li> <li>• Угаарын хийн хордлогоос сэргийлцгээе /постер 3 удаа/</li> <li>• Ямар нөхцөлд угаарын хий ихээр ялгардаг вэ? /цуврал зөвлөмж 3 удаа/</li> <li>• Угаартсан үед гэрийн нөхцөлд анхны тусламжийг хэрхэн үзүүлэх вэ?</li> <li>• Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлье /цуврал зөвлөмж 3 удаа/ нийт 33 удаа мэдээлэл зөвлөмжийг хүргээд байна.</li> </ul> <p>Мэдээллийн эх сурвалж: ЭМЯ, НЭМГ, НЭМҮТ, ХӨСҮТ,ЗӨСҮТ-ийн албан ёсны цахим хуудас болон facebook, page</p>

7	<p>НЭМГ-ын даргын 2019 оны А/59 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах, биелэлтийг 9 дүгээр сарын 11-ний өдрийн дотор ЭТХ-т ирүүлэх</p>	<p>Эмнэлгийн тусламж үйлчилгээг шинэчлэн зохион байгуулах, өргөжүүлэх чиглэлээр хийсэн ажлууд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. 2016 онд нярайн эмгэгийн тасгийг шинээр нээж үйл ажиллагааг нь эхлүүлэх Тус амаржих газар нь 2015 онд нярайн эмгэгийн 23 ортой тасгийг нярайн хүлээн авах хэсгийн хамт шинээр нээсэн. Одоогоор тус тасагт 3000 гаруй нярайд тусламж үзүүлж, хүлээн авах хэсгээр 20000 орчим төрсний дараах 28 хоногийн доторхи нярай үйлчлүүлээд байна.</li> <li>2. 2016 онд Хүүхдийн төрөлжсөн мэргэжлийн тасаг Нярайн эрчимт эмчилгээний тасагт зүрхний эмгэгийн оношилгооны хэсэгтэй болж дараах үйл ажиллагааг эхлүүлээд байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Оношилгооны тоног төхөөрөмжийг бүрдүүлэх зорилгоор зүрхний эх-ны аппарат 2016 онд суурилуулан жил бүр 500 орчим нярайд үзлэг нийж байна.</li> <li>• Хүүхдийн зүрх судасны эмчийг дотоод нөөц бололцоо ашиглан мэргэшүүлж одоогоор 2 зүрх судасны эмчийн ажлыг хавсран гүйцэтгэж байна.</li> </ul> </li> <li>3. Нян судлалын лаборатори-стандарт хангасан лабораторитой болох бэлтгэлийг байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган дэс дараалалтай алхмууд хийгдэж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• 2017-2018 онд олон эмэнд дасалтай нян илрүүлэх шинжилгээг нэвтрүүлэн, одоогийн байдлаар 9400 орчим шинжилгээ хийгдсэн байна.</li> </ul> </li> <li>4. Лабораторийн олон улсын магадлан итгэмжлэлийн болзол хангах <ul style="list-style-type: none"> <li>• 2019 оноос “И-КЛИНИК ХХК”-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж одоогоор эх барихын тасгийн 3 хэсгийг дотоод сүлжээнд холбоод байна.</li> <li>• Дараагийн шатанд бусад тасаг хэсгүүдийг дотоод сүлжээнд холбох бэлтгэл хийгдэж байна.</li> <li>• 2020 онд лабораторийн орчныг олон улсын жишигт нийцүүлэн урсгал засвар хийж тохижууллаа.</li> </ul> </li> </ol>
---	--	--